



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2013 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 11 дүгээр тушаалд дор дурдсан өөрчлөлт оруулсугай.

1.1. Тушаалын 4 дэх заалтыг "Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх эрх олгогдсон аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллахыг "Авто тээврийн үндэсний төв" УТҮГ /Т.Болдбаатар/-т, гэрээг батлахыг Зам, тээврийн дэд сайд /Х.Ержан/-д тус тус даалгасугай" гэж өөрчлөн найруулах;

1.2. Тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улс, БНХАУ-ын хооронд байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэхэд тавигдах шаардлага"-ын 1.1.12. "Тээврийн хэрэгсэл бүр дээр улс хоорондын ачаа тээвэрлэлтэд тавигдах нэмэлт шаардлагыг хангаж буй тухай авто тээврийн улсын байцаагчийн дүгнэлттэй байх" гэсэн заалт нэмэх;

1.3. Тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Х.Бат-Оргил, Э.Оюунтунгалаг нарыг хасаж Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Н.Чулуунбаатар, "Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газрын авто тээврийн хяналт хариуцсан мэргэжилтэн Д.Энх-Амгалан нарыг нэмэх;

1.4. Тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улс, БНХАУ-ын хооронд байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх гэрээ"-ний "Батлав. Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батбаатар" гэснийг "Батлав. Зам, тээврийн дэд сайд Х.Ержан" гэж өөрчлөх;

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Батзаяа/-д даалгасугай.



АГАНСҮХ